



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/3687

Арвайхээр сум

Электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг
худалдан борлуулахыг хориглосонтой холбогдуулан
авах арга хэмжээний тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Тамхины хяналтын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.7.7, 11 дүгээр зүйлийн 11.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.10, Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 23-ны “Утаат болон электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглох тухай” А/136 дугаар захирамжийн хэрэгжилтэд тавих хяналтыг эрчимжүүлж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулсугай.

2.Иргэд, өсвөр үе, залуучуудыг тамхинаас үүдэлтэй өвчин, эмгэгээс урьдчилан сэргийлэх, утаат болон электрон тамхины хор уршгийг таниулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Сайнжаргал)-т, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний агентлаг Эрүүл мэндийн газар (Д.Шивааннүрдэв)-т, аймгийн Цагдаагийн газар (Г.Чимэддавга)-т, сумын Засаг дарга нарт тус тус үүрэг болгосугай.

5.Захирамжийн биелэлт, арга хэмжээний үр дүнг хагас, бүтэн жил тутамд дүгнэж, үр дүн, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналын хамт аймгийн Засаг даргын зөвлөлд танилцуулж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтэс (Б.Сайнжаргал)-т даалгасугай.

6.Аймгийн Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 23-ны “Утаат болон электрон тамхи, түүний дагалдах хэрэгслийг худалдан борлуулахыг хориглох тухай” А/136 дугаар захирамжийн хавсралтыг хүчингүй болсонд тооцсугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

6223 11 0632

D:My Doc. Zahiramj. Zasag darga

Аймгийн Засаг даргын 2023 оны 25 дугаар
сарын 11-ны өдрийн А/Б/К дугаар
захирамжийн хавсралт



Ажлын хэсгийн бүрэлдэхүүн

Ажлын хэсгийн ахлагч: Б.Сайнжаргал (аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн дарга)

Гишүүд:

А.Отгонцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга)

Н.Чимэддорж Ойдов (аймгийн Боловсрол, Шинжлэх ухааны газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Н.Цэвээндулам (аймгийн Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Алтанцацрал (аймгийн Цагдаагийн газрын Урьдчилан сэргийлэх ажил хариуцсан ахлах мэргэжилтэн, цагдаагийн хошууч)

Э.Есөн-Эрдэнэ (аймгийн Хүнс, хөдөө, аж ахуйн газрын Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч)

Г.Амардэлгэр (Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газрын Өвөрхангай аймаг дахь улсын байцаагч)

Сумдын Засаг дарга

Ерөнхий боловсролын сургуулийн захирал нар

Ш.Мөнхцэцэг (аймгийн Засаг даргын Тамгын газрын хэвлэл мэдээллийн ажилтан)

Нарийн бичгийн дарга: М.Золзаяа (аймгийн Эрүүл мэндийн газрын Нийгмийн эрүүл мэндийн хэлтсийн дарга)